

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

**2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр, Лхагва гараг**

**Хуралдааны тэмдэглэлийн агуулга**

<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	1-4
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	5-21
<hr/>	
1.Цөмийн аюулгүй ажиллагааны тухай конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.11.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, <b>соёрхон батлах/</b>	5-13
2.Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.11.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, <b>соёрхон батлах/</b>	13-16
3.Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.11.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, <b>соёрхон батлах/</b>	16-21

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы  
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны  
11 дүгээр сарын 27-ны өдөр /Лхагва гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 22 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Ч.Анар, П.Наранбаяр;  
Чөлөөтэй: Б.Батбаатар, Б.Дэлгэрсайхан, Х.Тэмүүжин;  
Эмнэлгийн чөлөөтэй: Н.Номтойбаяр;  
Тасалсан: О.Амгаланбаатар, Б.Жаргалан, Г.Хосбаяр.

**Нэг.Цөмийн аюулгүй ажиллагааны тухай конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.11.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Техник, технологийн хэлтсийн дарга Г.Намчинсүрэн, мөн яамны Цөмийн болон цацрагийн хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Э.Цэрэнчимэг, Эрдэс баялгийн бодлогын газрын ахлах шинжээч Н.Од-Эрдэнэ, Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Соёлмаа, Цөмийн энергийн комиссын Ажлын албаны Тамгын газрын дарга Б.Баатарцогт, мөн комиссын Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга Э.Нямдаваа, мөн газрын ахлах мэргэжилтэн Г.Гэрэлмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх С.Дунжидмаа, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа нар байлцав.

Төслийн талаар Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбатын тавьсан асуултад Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Техник, технологийн хэлтсийн дарга Г.Намчинсүрэн, Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Соёлмаа нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд нар үг хэлэв.

**Г.Тэмүүлэн:** Цөмийн аюулгүй ажиллагааны тухай конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13  
Татгалзсан: 2  
Бүгд: 15  
86.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 15 цаг 46 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.11.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Техник, технологийн хэлтсийн дарга Г.Намчинсүрэн, мөн яамны Цөмийн болон цацрагийн хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Э.Цэрэнчимэг, Эрдэс баялгийн бодлогын газрын ахлах шинжээч Н.Од-Эрдэнэ, Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Соёлмаа, Цөмийн энергийн комиссын Ажлын албаны Тамгын газрын дарга Б.Баатарцогт, мөн комиссын Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга Э.Нямдаваа, мөн газрын ахлах мэргэжилтэн Г.Гэрэлмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх С.Дунжидмаа, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа нар байлцав.

Төслийн талаар Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан танилцуулав.

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат нар үг хэлэв.

**Г.Тэмүүлэн:** Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 4  
Бүгд: 15  
73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Жангабыл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 15 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.*

**Гурав.Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.11.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Техник, технологийн хэлтсийн дарга Г.Намчинсүрэн, мөн яамны Цөмийн болон цацрагийн хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Э.Цэрэнчимэг, Эрдэс баялгийн бодлогын газрын ахлах шинжээч Н.Од-Эрдэнэ, Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Соёлмаа, Цөмийн энергийн комиссын Ажлын албаны Тамгын газрын дарга Б.Баатарцогт, мөн комиссын Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга Э.Нямдаваа, мөн газрын ахлах мэргэжилтэн Г.Гэрэлмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх С.Дунжидмаа, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа нар байлцав.

Төслийн талаар Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, Н.Батсүмбэрэл нарын тавьсан асуултад Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан хариулж, тайлбар хийв.

**Г.Тэмүүлэн:** Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 5  
Бүгд: 15  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн саналыг дэмжсэнээр тооцож, 73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Жангабыл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 16 цаг 11 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 49 минут үргэлжилж, 25 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 64.0 хувийн ирцтэйгээр 16 цаг 11 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр,  
Лхагва гараг  
Төрийн ордон "Их засаг" танхим  
15 цаг 22 минут.

### АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Г.Тэмүүлэн:** Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Та бүхэнд ирцийг танилцуулъя. Наранцэцэгийн Алтаншагай гишүүн, Энхтайваны Бат-Амгалан гишүүн, Энхбатын Болормаа гишүүн, Хажекберийн Жангабыл гишүүн, Нанзадын Наранбаатар гишүүн, Пүрэвжавын Сайнзориг гишүүн, Дамдины Цогтбаатар гишүүн, Өлзийхүүгийн Шижир гишүүн, Баттөмөрийн Энхбаяр гишүүн, Жадамбаагийн Энхбаяр гишүүн, Лутаагийн Энхнасан гишүүн, Сүхбаатарын Эрдэнэболд нарын гишүүд хүрэлцэн ирснээр өнөөдрийн Байнгын хорооны хуралдааны ирц бүрдсэн байна.

Ингээд 11 сарын 27-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал 3 асуудлууд байгаа. Хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1 дүгээрт, Цөмийн аюулгүй ажиллагааны тухай конвенцыг соёрхон батлах тухай,

2 дугаарт, Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай байна.

3 дугаарт, Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг соёрхон батлах тухай гэсэн ийм 3 асуудлууд байна.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа орцгооё.

1 дүгээр асуудал.

**Цөмийн аюулгүй ажиллагааны тухай конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг явуулъя.**

Ажлын хэсгийн албан тушаалтнуудыг оруулаарай.

Цөмийн аюулгүй ажиллагааны тухай конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Цэвэгдоржийн Туваан сайд танилцуулна. Туваан сайдын микрофоныг өгье.

**Ц.Туваан:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Улсын Их Хурал 2009 онд Цөмийн энергийн тухай хууль болон Монгол Улсын төрөөс цацраг идэвхт

ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлогыг баталж. Улсын Их Хурлаас 2010 онд батлан гаргасан Монгол Улсын Үндэсний аюулгүй хуулийн зөвлөлийн үзэл баримтлалын 3.2.4.4-д цөмийн эрчим хүчний салбарыг үндэсний ашиг сонирхол. энхийн зорилгоор ашиглах зарчимд нийцүүлэн хөгжүүлнэ. Цөмийн циклийг хөгжүүлж цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалт, боловсруулалт, хөрвөлт, баяжуулалт, эрчим хүчний үйлдвэрлэлийг бий болгож бэхжүүлнэ. 3.5.4.4-д түүхий нүүрсийг дулааны аргаар гүн боловсруулах, хийжүүлэх, шингэрүүлэх замаар эрчим хүч, дулааны үйлдвэрлэл, ахуйн хэрэглээний цэвэр түлш үйлдвэрлэх аливаа үйлдвэрлэлийн технологид хэмнэлттэй дэвшилтэт байх шаардлагыг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр дамжуулан тавина. Нар салхины сэргээгдэх эрчим хүч ашиглалтыг нэмэгдүүлж, цөмийн эрчим хүчийг ашиглана гэж тус тус заасан.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болох Алсын хараа 2050-д нэмүү өртөг шингэсэн уул уурхайн бүтээгдэхүүн боловсруулах аж үйлдвэр, эрчим хүчний үйлдвэр зэрэг стратегийн ач холбогдол бүхий эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлэх зорилт тусгагдаж, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 08 сарын 10-ны өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцэж баталсан Монгол Улсын Засгийн газрын 2024-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.7-д ураны нөөцийг түшиглэн АЦС барих бодлого хэрэгжүүлж, суурь судалгааг хийнэ гэж тусгасан бөгөөд Олон улсын атомын энергийн агентлагаас цөмийн эрчим хүч барьж байгуулахаар төлөвлөж буй 27 улсын жагсаалтад Монгол Улсыг оруулсан байна.

Монгол Улсын Их Хурлын 2015 оны 06 сарын 19-ний өдрийн Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид байх статусыг шинэ түвшинд гаргах тухай 60 дугаар тогтоолоор Цөмийн аюулгүй ажиллагааны 94 оны конвенц, Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 80 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлт болон Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколд нэгдэн орох арга хэмжээ авахыг Засгийн газарт даалгасан байдаг.

Тус Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор уг конвенцод нэгдэн орох асуудлыг Засгийн газрын 23 оны 08 сарын 23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хурлын Байнгын хороотой зөвшилцөхөөр тогтсон. Түүнчлэн Улс Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 23 оны 11 сарын 21-ний өдрийн хуралдаанаар уг конвенцыг дэмжсэн болно.

Цөмийн аюулгүй ажиллагааны 94 оны конвенц соёрхон батлах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Гадаад харилцааны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд 2024 оны 10 сарын 13-ны өдөр баталсан. Засгийн газрын 2024 оны 11 сарын 13-ны өдрийн хуралдаанаар Цөмийн аюулгүй ажиллагааны тухай 94 оны конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 79.1-д заасны дагуу хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд 11 сарын 22-ны өдөр өргөн мэдүүлсэн болно.

Монгол Улс нь цөмийн байгууламжгүй хэдий ч цөмийн түлшний циклийг бүхэлд нь хэрэгжүүлдэг цөмийн зэвсэгтэй 2 их гүрний дунд оршиж байдаг газар зүйн онцлогтой. ОХУ, БНХАУ-ын цөмийн байгууламжийн аюулгүй байдал нь тухайн улсын хяналтын байгууллага чанд хяналтад байдаг хэдий ч болзошгүй

ослын үед манай улсын хил дамнасан цацраг идэвхт бохирдол үүсэх эрсдэл байх боломжтой. Шинээр барьж буй болон үйл ажиллагаа явуулж буй цөмийн байгууламж нь түүний ойр орчимд байх хөрш зэргэлдээ улсын нутаг дэвсгэрт нөлөөлж болзошгүй учир тухайн талтай зөвлөлдөх хүсэлт гаргасан тохиолдолд цөмийн байгууламжийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл авах замаар өөрийн нутаг дэвсгэр дээр үүсэж болзошгүй гаднын нөлөөллийг тооцох, аюулгүй ажиллагааны үнэлгээг хийх, хил дамнасан ослын үед авах арга хэмжээний төлөвлөлтийг сайжруулах, хариу арга хэмжээ авах нөхцөл бүрдэх юм. Ингэснээр өөрийн орны хүн ам, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах, аюулгүй байдлыг хангах боломж бүрдэнэ.

Цөмийн байгууламжтай шууд холбоотой үйл ажиллагаа эрхэлж буй бүх байгууллага цөмийн аюулгүй ажиллагааг тэргүүн ээлжид хангах бодлого боловсруулж, мөрдөх нөхцөлийг хангахад чиглэсэн зохих арга хэмжээ авч хэрэгжүүлэх үүрэгтэй. Цөмийн байгууламжийн үйл ажиллагаа нь бүхий л үе шатад тухайн байгууламжид ажиллагсад болон хүн амд үзүүлэх цацрагийн шарлагын хэмжээг байж болох хамгийн бага түвшинд байлгах нөхцөлийг хангах, цөмийн байгууламжийн биет байдал, түүний үйл ажиллагаа, зураг төсөл, аюулгүй ажиллагааны холбогдох үндэсний шаардлагууд болон үйл ажиллагааны нөхцөл, хориг, хязгаарлалтад нийцэж буй эсэхийг судалгаа шинжилгээ явуулах туршилт, шалгалт хийх замаар тогтоож баталгаажуулах, цацрагийн осолд өртөх магадлалтай байвал цөмийн байгууламжийн хөрш зэргэлдээ орших өөрийн хүн ам болон эрх бүхий байгууллагуудыг ослын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө, хариу арга хэмжээний талаар холбогдох мэдээллээр хангахад чиглэсэн зохих арга хэмжээ авах шаардлагатай байдаг.

Цөмийн энергийг энхийн зорилгоор ашиглахад цацрагийн сөрөг нөлөөллөөс хүн ам, нийгэм, хүрээлэн буй орчныг хамгаалах хяналтын тогтолцоо бий болох шаардлагатай тохиолдолд олон улсын хамтын ажиллагааны хүрээнд техникийн дэмжлэг туслалцаа авч болно. Конвенцод нэгдэн орсноор Монгол Улс санхүүгийн ямар нэгэн үүрэг хүлээхгүй. Монгол Улсад мөрдөгдөж байгаа хууль бусад хууль тогтоомжтой зөрчилдсөн зүйл заалт байхгүй болно.

Цөмийн аюулгүй ажиллагааны тухай 94 оны конвенцыг Олон улсын атомын энергийн агентлагийн гишүүн орнуудын санаачилгаар 94 онд баталж, 96 оны 10 дугаар сарын 24-нд хүчин төгөлдөр болсноос хойш одоогийн байдлаар 96 улс нэгдэн орсон байна.

Иймд Цөмийн аюулгүй ажиллагааны тухай 94 оны конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэн дэмжиж өгөхийг хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Г.Тэмүүлэн:** Туваан сайдад баярлалаа.

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн нэрсийг танилцуулъя.

Аж үйлдвэр эрдэс баялгийн сайд Цэвэгдоржийн Туваан, Аж үйлдвэр, эрдэс аялгийн яамны Хуулийн хэлтсийн дарга Туулхангайн Ганбаатар, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Техник, технологийн хэлтсийн дарга Гүнчинсүрэнгийн Намчинсүрэн, ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн

дарга Нармандахын Жамъянхүү, ГХЯ-ны Гэрээ, эрх зүйн газрын захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Жамбалдоржийн Соёлмаа, Цөмийн энергийн комиссын ажлын албаны Тамгын газрын дарга Балдоржийн Баатарцогт, Цөмийн энергийн комиссын Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга Энхгэрэлийн Нямдаваа, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын ахлах шинжээч Нямдолгорын Од-Эрдэнэ, Цөмийн энергийн комиссын Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын ахлах мэргэжилтэн Гомбосүрэнгийн Гэрэлмаа, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Цөмийн болон цацрагийн хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Энхболдын Цэрэнчимэг гэсэн бүрэлдэхүүн оролцож байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулаад хууль санаачлагчаас асуух асуулттай гишүүд байна уу? Гишүүдийн нэрсийг авъя. Ганбат гишүүнээр тасалъя. Ганбат гишүүн асуултаа асууя.

**Д.Ганбат:** Оройн мэнд. Ийм чухал асуудал хэлэлцэж байхад чинь яахаараа би ганцаараа асуудаг билээ. Та зөв бүртгэв үү, яав, тийм үү.

1 дүгээр асуулт. Их л чухал конвенцод нэгдэх гэж байгаа юм байна. Өмнө нь хэр олон конвенцод нэгдсэн билээ. Конвенцод нэгдэнэ ээ гэдэг чинь бид нар чинь өөрөө тэр конвенцыг дагаж мөрдөж явах ёстой л доо. Тэгээд өмнө нь нэгдсэн конвенцоосоо тийм биелүүлээгүй, бариагүй тийм конвенц байдаг билүү, манайд. Байгаа бол яагаад тэр конвенцынхоо зүйл, заалтыг биелүүлээгүй, нэгдчихээд хэрэгжүүлээгүй юм бэ? Ямар учир шалтгаан байсан юм? Энэ конвенцод нэгдчихээд бид нар тэрийгээ яг биелүүлэх үү? Бас биелүүлэхгүй байж болох юм уу? Яах юм бол. Уул нь конвенцод нэгдсэн бол нэлээн судалж байж, тэгээд 1 нэгдчихсэн бол тэрийгээ биелүүлээд явах ёстой л доо. Тэгэхгүй бол энэ улс орны нэр хүнд гэдэг чинь олон улсын тавцан дээр байхгүй болчхож байна шүү дээ. Ямар конвенцод нэгдэх вэ, ямар конвенцод нэгдэхгүй вэ гэдгийгээ урьдчилан бид нар сайн судалж байж, хариуцлагатай нэгдэхгүй бол нэгэнт нэгдсэн конвенцоосоо дараа нь ямар нэгэн байдлаар биелүүлдэггүй, тэр хэмжээгээрээ улс орны нэр хүнд унадаг ийм байдалтай болчхоод байна. Ийм эрсдэл байгаа юу, байхгүй юу? Тэрийг та бүхнээс асууя.

**Г.Тэмүүлэн:** Ганбат гишүүний асуултад хариулья. Хаанаас хариулах вэ? Туваан сайд.

**Ц.Туваан:** Нарийн хэдэн хувийн конвенцтой конвенцод нэгдсэн бэ, биелүүлээгүй бол яах вэ гэдэг талаар манай ажлын хэсэг бэлдэж байгаарай.

Энэ бид нар нөгөө саяхан Цөмийн энергийн тухай хууль хэлэлцсэн. Дээрээс нь бид нар одоо Олон улсын өмнө Францтай энэ Рона компанитай хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах гэж байгаа энэ цаг үед буюу энэ конвенцод нэгдэх асуудлыг оруулж ирж байгаа. Яагаад вэ гэхээр энэ асуудлууд манай Их Хурлаар тухайлах юм бол Байнгын хороогоор ороод, Засгаар ороод ингээд бэлэн болчихсон.

Дээрээс нь цаг хугацааны хувьд нэлээн хоцроод явж байсан. Ийм Их Хурлын цаг зав болохгүй байсан. Ийм асуудлуудыг бид нар энэ олон улсын хөрөнгө оруулалтын гэрээ зурахынхаа үеэр оруулж ирж байгаа юм. Тэгээд энэ конвенц бол нэгдэн орсноор энэ конвенцын шаардлагуудаа бид нар биелүүлээд явна. Одоо маш чухал батлахаас, зайлшгүй батлах шаардлагатай ийм конвенц

байгаа. Эдгээр 3, үүнээс гадна 2 конвенц байгаа. Эдгээр конвенцуудад нэгдэн орохгүй бол энэ ондоо багтаж Улсын Их Хурлаар хэлэлцэхгүй бол олон улсын санхүүд орох хэмжээний конвенц ч бас байгаа гэдгийг хэлье. Тэгээд ажлын хэсэг өмнөх конвенцуудын талаар.

**Г.Тэмүүлэн:** 2 номер.

Ганбат гишүүний асуултад хариулъя. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам Эрдэс баялгийн бодлогын газрын дарга Намчинсүрэн.

Манай улс бол Олон улсын атомын энергийн агентлагийн мөрдөж байгаа үндсэндээ 10 төрлийн гэрээ, конвенц, протоколд нэг орсон байдаг. Тухайлах юм бол 1963 онд Цөмийн зэвсгийг агаар мандал, огторгуй, уудам усан доор туршихыг цаазлан хориглох гэрээ 1963 онд нэгд орсон. 68 онд Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх тухай гэрээнд нэгдэн орсон. 1971 онд Тэнгис далайн ёроол, түүний хөрсөн доор цөмийн болон үй олноор хөнөөх бусад зэвсгийг байрлуулах, хориглох тухай гэрээнд бас нэгдэн орсон. 1972 онд Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх гэрээтэй холбогдуулан баталгаа хэрэглэх тухай хэлэлцээрт нэгдэн орсон. Энэ хэлэлцээрт одоо өнөөдөр өргөн барьж байгаа 3 гэрээний 1 нь энэ хэлэлцээр байгаа. Нэмэлт, өөрчлөлт нь орохоор ... /минут дуусав/

**Г.Тэмүүлэн:** 2 номер минут нэмээд өгье.

**Г.Намчинсүрэн:** 1987 онд болохоор Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай конвенц, Цөмийн ослын талаар шуурхай мэдүүлэх конвенц, Цөмийн болон цацрагийн аюултай байдал бий болсон тохиолдолд тусламж үзүүлэх тухай конвенцод нэгдэн орсон. 2003 онд Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх гэрээтэй холбогдуулан баталгаа хэрэглэх тухай Монгол Улс, Олон улсын атомын энергийн агентлаг хооронд байгуулсан хэлэлцээрийн нэмэлт протокол. 2006 онд Цөмийн террорист үйлдлийг хориглох тухай конвенц, 2021 онд Цөмийн зэвсгийг хориглох тухай гэрээнд нэгдэн орсон.

Сая сайд хэллээ. Үндсэндээ биелүүлээгүй конвенц гэдэг ойлголт байхгүй. Харин Олон улсын атомын энергийн агентлагаас 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдөр Монгол Улсын Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Цөмийн энергийн комиссын даргад Олон улсын атомын энергийн агентлагийн захирлуудын зөвлөлийн шийдвэр 2005 онд гарснаас хойш багагүй хугацаа өнгөрсөн тул Монгол Улс энэ ... /минут дуусав/

**Г.Тэмүүлэн:** Гадаад яам нэмж хэлэх мэдээлэл байгаа юу, гайгүй юу. Зүгээр үү.

Тодруулчихъя. Ганбат гишүүн тодруулъя.

**Д.Ганбат:** Яагаад хариулт өгөхгүй байна. Би тов тодорхой зүйл асуугаад байхад ерөөсөө хариулахгүй юм. Эсвэл тэр хариултыг нь өгч чаддаг хүмүүсийг нь суулгамаар байна, дарга аа. Ер нь тэгээд энэ олон улсын конвенцод нэгдэнэ ээ гэдэг чинь дотоодын хууль журам шиг л яг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хэрэгжээд л явна шүү дээ.

Тэгэхээр бас одоо хууль хэрэгжээд явж байхад дунд нь зогсоож барьдаг тийм юм гарч эхэлж байна уу, үгүй юү? Сураг нь. Одоо яах юм, тэгээд конвенц хэрэгжээд явахаар дунд нь зогсоож болох тийм юм байна уу. Тийм юм хийх үү, үгүй юү? Тийм. Бас нэг аливаа хууль ч бас нэг жишиг л байдаг л даа. Үүнийг нь тодруулчихъя. Бид нар баахан хууль батлаад л байдаг, конвенцод нэгдээд л байдаг.

**Г.Тэмүүлэн:** Нэмж хариулах уу? Туваан сайд. Гадаадын ерөнхийдөө юм хэлчихье. ерөнхий нийт конвенцуудынхаа хүрээнд үүсэх эрсдэл энэ тэр байгаа юу, үгүй юү гэдэгт тодорхой хариулт өгчхөөрэй. Туваан сайд.

**Ц.Туваан:** Бид нар улсынхаа хувиар олон улсын харти дүрмүүдийг мөрдөж явдаг. Үүний дотор энэ цөмийн энергитэй холбоотой асуудал бол маш нарийн зохицуулалтуудаар явагддаг, маш олон тодорхой заалтуудтай конвенцуудаар явдаг. Тэгэхээр үүний нэг нь болох энэ Цөмийн аюулгүй ажиллагааны энэ 94 оны конвенц байгаа. Тэгээд энэ конвенц маань өөрөө яах вэ, заавал дагаж мөрдөх бичиг баримт. Тэгээд цөмийн байгууламжуудын аюулгүй ажиллагаатай холбоотой энэ заавал дагаж мөрдөх олон улсын гэрээ юм байгаа юм.

Тэгээд энэ цөмийн байгууламжуудад хяналт тогтоох зорилготой Олон улсын атомын энергийн агентлагаас гаргасан энэ Чернобылийн АЦС-ын дэлбэрэлтээс хойш л анх гарсан ийм конвенц юм л даа. Тэгээд энэ дээр байгаль орчинд энэ цөмийн байгууламжууд хэр ээлтэй байх вэ, ард иргэдэд аюулгүй байх гэдэг асуудлаа хэр хангасан бэ гэдгийг л хянадаг ийм конвенц байгаа.

**Г.Тэмүүлэн:** Гадаад яам 6 номер.

**Ж.Соёлмаа:** Ганбат гишүүний асуултад хариулъя. Одоогийн байдлаар Монгол Улс 305 олон улсын гэрээ, конвенцод нэгдэж орсон байгаа. Гэрээ конвенцод нэгдэж ороход ерөнхийдөө энэ эхний ээлжид шаардлагатай тухайн конвенцынхоо зохицуулалтынхаа хүрээнээс хамаараад нэг бол дотоодын хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулах замаар үүргээ биелүүлдэг. Нэг бол тухайн конвенцын дагуу тайлан хамгаалах замаар үүргээ биелүүлдэг. Нөгөө талаасаа магадгүй нөгөө санхүүгийн үүрэг хүлээсэн конвенцын хувьд гэх юм бол тухайн байгууллагын гишүүнчлэлийн санхүүгийнхээ төлбөрийг төлөх замаар ингээд үүргээ биелүүлдэг. Ийм 3 төрлийн конвенцын хэрэгжилт хангагддаг байгаа.

Өнөөдөр яригдаж байгаа энэ цөмийн конвенцын хувьд гэх юм аливаа нэмэлт үүрэг байхгүй. Дотоодын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй ийм конвенцын төрөл байгаа. тэгээд мөн манай яамнаас яг нэгдэж орсон конвенцуудын хэрэгжилтийг хэрхэн үнэлэх ийм ийм хийгддэг ... /минут дуусав/

**Г.Тэмүүлэн:** Нэмээд минут өгье. 6 номер.

**Ж.Соёлмаа:** Тэр хэрэгжилтийн талаарх нэгдэн орсон конвенцуудынхаа хэрэгжилтийг хэрхэн хангаж байгаа талаар товч мэдээлэл ингэж дүгнэгдэж явдаг байгаа. Тэр мэдээллийг Ганбат гишүүнд нэмэлтээр өгч болно. Баярлалаа.

**Г.Тэмүүлэн:** Баярлалаа Соёлмаа даргад.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Үг хэлэх гишүүд байна уу? Эрдэнэболд гишүүнээр тасалъя. Эрдэнэболд гишүүн.

**С.Эрдэнэболд:** Энэ асуудал маань яах вэ, Улсын Их Хурлын чуулган дээр бид нар нөгөө яаралтай горимоор явж оруулсан. Тэгээд энэ хугацаанд нэг зүйл ажиглагдсан зүйл нь болохоор ер нь иргэдийг хэрхэн мэдээлэлжүүлсэн бэ? Олон нийтэд энэ чиглэлээр мэдээж энгийн танин мэдэхүйн зүгээс өгсүүлээд ахисан түвшний мэдээлэл, магадгүй гүнзгий түвшний мэдээлэл хэр зэрэг өгсөн бэ гэдэг асуудал дээр их төвлөрөх зайлшгүй шаардлагатай харагдаж байгаа. Монгол Улсын хувьд мэдээж хөгжил дэвшлийн тухай хэт хүрэн эдийн засгаасаа илүүтэйгээр олон тулгуурт эдийн засаг, эдийн засгийн эх сурвалжуудаа бид нар алхам алхмаар баталгаажуулж, тэгээд засаг хамтарсан үе дээр энэ чиглэлээр зоригтой алхмууд хийх зайлшгүй шаардлага байгаа.

Тэгээд гол асуудал нь болохоор тэр ажлын хэсгийн хуралдаан дээрээс ингээд харж байхад нэг 7000 орчим хүнд бичиж танилцуулсан гэсэн байсан. Тийм ээ, 7000 орчим хүнд. Энхбаяр гишүүн ээ, манайхан би нэг үг хэлээд дуусгаадахъя, одоохон.

Тэгэхээр ер нь яах вэ, 7000 хүн гэдэг бол хангалтгүй байгаа юм. Энэ яаж байна гэхээр биечилж очиж үзэж байгаа 7000 хүнээс гадна хэвлэл мэдээллээр баталгаатай, найдвартай, олон талт эх сурвалжийг авах нь зайлшгүй хэрэгтэй байгаа юм. Тийм учраас та бүхэн үйл ажиллагаандаа олон нийтийг мэдээлэлжүүлэх чиглэл дээр бүр ийм тодорхой хөтөлбөртэй, цаг хугацаатай, магадгүй төсөв мөнгөтэй энэ ажлыг төлөвлөгөөндөө оруулах зайлшгүй шаардлага харагдаад байна лээ. Тэгэхгүй болохоор нөгөө мэдээллийн хоосон байгаа орон зай, мэдээлэлгүй байгаа орон зай дээр чинь янз бүрийн гуйвуулга, гүтгэлэг, улс төрийн мессеж, магадгүй манай улсын дотоод эрх ашгаас гадна гадаадаас ч нөлөөлж болзошгүй тийм зүйлүүд явахыг үгүйсгэхгүй байгаа юм.

Тэгэхээр ер нь мэдээж энэ чиглэлээр бид нар хүний нөөцөө чадавхжуулах, энэ чиглэл дээр хөрөнгө зарцуулалт хийх, энэ чинь яагаад гэхээр энэ төслүүд ингээд цаашаагаа явна. Хуулийн хэрэгжилтийн хүрээ чинь улам л гүнзгийрээд явах учраас энэ хүний нөөцөө бэлтгэх, гэхдээ олон нийтэд үүнийг олон талын зөв мэдээллийг өгөх ажил дээр ажлын хэсгийнхэн онцгой анхаарах шаардлага ажиглагдаж байгаа юм. 7000 биш 70000 хүн, 700000 хүн маш сайн мэдээлэлтэй байх тухай ойлголт л байгаад байгаа юм. Тэгэхгүй болохоор нөгөө яаралтай горимоор орж ирсэн. Их Хурлын гишүүдийн ихэнх нь ч гэсэн танин мэдэхүйн мэдээлэлтэй, тэгээд нөгөө гэрээ болон төсөл 2-ын хооронд нь хуулийн төсөл 2-ын хооронд нь ялгахгүй асуудлууд гарч ирсэн.

Дээрээс нь нэмэх нь яг энэ үетэй давхцаад Ховдын Халзан Бүрэгдэйн асуудал эд нар гээд ер нь олон асуудлууд орж ирсэн. Шар нунтгийн асуудал эд нар гээд л маш олон төрлийн зүйлүүд яриад байгаа. Тэгээд нөгөө яг энэ бодлого боловсруулж байгаа, шийдвэр гаргаж байгаа түвшнээс мөн ажлын хэсгээс энэ олон нийтийн мэдээллийн хэрэгслээр эх сурвалж нь баталгаатай мэдээллийг олон нийтэд өгөхгүй бол хууль нь батлагдчихлаа, асуудал нь шийдэгдчихлээ гээд орхичих юм бол ар дээр нь баахан асуултын тэмдэг үлдэнэ. Тэр асуултын тэмдэг чинь цаашаа үрэвсээд, юу болох вэ гэхээрээ энэ цаашаа энэ хуулийн хэрэгжилт амжилттай зохион байгуулагдах, дараа дараагийн төсөл, хөтөлбөрүүд хэрэгжихэд саад болох ийм магадлалтай байгаа.

Тийм учраас дүгнээд хэлэхэд Монгол Улсын энэ 2010 оны батлагдсан үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд энэ үзэл санаа маань хэр зэрэг нийцэж байгаа, энэ нь эргээд Монгол Улсад эдийн засгийн хувьд болон тусгаар тогтнол, үндэсний үнэ цэн авчрахад ямар ач холбогдолтой тал дээр нь цааш цаашдаа яаман дээр болон энэ ажлын хэсгүүд нэг ийм платформ буюу ажендаа гаргаж явах шаардлагатай.

126 дотроо батлагдаад ингээд цаашаа гараад явчихдаг. Нийгэмд л эргээд нөгөө танин мэдэхүйн шинж чанартай зүйлүүд асуулт хэвээрээ үлдэнэ. Тэгээд 1 юм батлагдчихлаа гэдэг цаашаа явахаар энэ чинь эргээд нөгөө нэг хүмүүст мэдээлэл нэвчиж, хүлээн зөвшөөрөгдөх, хангалттай олон талын эх сурвалжууд нь хоногших, энэ бүх зүйлүүд үгүйлэгдсэн хэвээр байгаа шүү гэдгийг ... /минут дуусав/

**Г.Тэмүүлэн:** Эрдэнэболд гишүүнд баярлалаа.

Санал хураалт явуулахаар байгаад байгаа.

Би нэмээд яах вэ, товчхон мэдээлэл өгчихье. 2015 онд Улсын Их Хурлаас Засгийн газарт чиглэл өгсөн байгаа. Яг энэ Цөмийн аюулгүй ажиллагааны тухай 94 оны конвенцод нэгдэн орохыг Засгийн газарт даалгасан. Үүний дагуу ингээд Засгийн газар энэ асуудлыг ингээд оруулж ирж байна. Өмнөх парламентын үед буюу 2023 оны 11 сарын 21-нд яг энэ манай Байнгын хороо бас хуралдаад энэ конвенцод нэгдэн орох асуудлыг хэлэлцсэн байгаа. Ингээд сүүлийн эцсийн ингээд соёрхон батлах асуудал маань ингээд орж байгаа юм байна гэсэн мэдээллийг өгөх байна.

Тэгээд 94 онд батлагдсан энэ конвенцоор одоогийн байдлаар 96 онд нэгдэн орсон гэсэн. Яг цааш цаашдаа бид нар энэ олон улсын хамтын ажиллагааг яг энэ чиглэлээр бэхжүүлж яг энэ Монгол Улс цөмийн энергийг энхийн зорилгоор ашиглах гэдэг юм уу, олон улсын хэм хэмжээнд өөрсдийнхөө стандартыг нийцүүлэх, дүрэм журмаа нийцүүлэх ийм ач холбогдолтой ийм конвенц байгаа юм байна.

Ингээд санал хураалт явуулъя.

Цөмийн аюулгүй ажиллагааны тухай конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт.

Санал хураалтын дүнг танилцуулъя. Санал хураалтад 15 гишүүн оролцож, 13 гишүүн дэмжиж, 86,7 хувиар дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа.

Цөмийн аюулгүй ажиллагааны тухай конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганд танилцуулах байгаа. Алтаншагай гишүүн танилцуулъя.

Цөмийн аюулгүй ажиллагааны тухай конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

2 дахь асуудалдаа оръё.

**Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэж эхлүүлье.**

Оролцож байгаа албан тушаалтнууд мөн адил түрүүн танилцуулсан ажлын хэсэг хэвээрээ байна.

Ингээд Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Цэвэгдоржийн Туваан сайд танилцуулна. Туваан сайдын микрофоныг өгье.

**Ц.Туваан:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Их Хурлын 2015 оны 06 сарын 19-ний өдрийн Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид байх статусыг шинэ түвшинд гаргах тухай 60 дугаар тогтоолоор Цөмийн материалыг материалыг биечлэн хамгаалах тухай 1980 конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлтөд нэгдэн орох арга хэмжээ авахыг Засгийн газарт даалгасан.

Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор уг конвенцын нэмэлт, өөрчлөлтөд нэгдэн орох асуудлыг Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хурлын Байнгын хороотой зөвшилцөхөөр тогтсон. Мөн түүнчлэн Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 23 оны 11 сарын 21-ний өдрийн хуралдаанаар уг конвенцын нэмэлт, өөрчлөлтийг дэмжсэн болно.

Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 80 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Гадаад харилцааны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд 2024 оны 10 сарын 13-ны өдөр баталсан. Засгийн газрын 2024 оны 11 сарын 13-ны өдрийн хуралдаанаар Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 80 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэж, Монгол Улсын Их Хурлын чуулганаар хуралдааны дэгийн тухай хуулийн 79.1-д заасны дагуу хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд 11 сарын 22-ны өдөр өргөн мэдүүлсэн.

Монгол Улсад эрүүл мэнд, аж үйлдвэр, геологи уул уурхай, ХАА, судалгаа, шинжилгээ хяналтын салбарт цөмийн технологийг анх 1934 оноос хэрэглэж ирсэн бөгөөд одоогоор 669 ААНБ-д 2327 цацрагийн эх үүсвэр ашиглаж байна. Цөмийн цацрагийн үүсгүүрийн хэрэглээ 1996 онтой харьцуулахад 5,8 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 80 оны конвенц нь зөвхөн олон улсын тээвэрлэлтийн үеийн биечлэн хамгаалах арга хэмжээнд хамаарч байсан бол 2005 оны нэмэлт, өөрчлөлт нь цөмийн байгууламж, түүнчлэн дотоодын хэрэглээ, хадгалалт, тээвэрлэлтэд байгаа цөмийн материалын аюулгүй байдлыг хангах асуудлыг хамаарч байна. Мөн конвенцод хамаарах гэмт хэрэгт цөмийн

материалыг хууль бусаар нэвтрүүлэх, цөмийн байгууламжид хорлон сүйтгэх ажиллагаа явуулах, хүрээлэн буй орчинд ноцтой хохирол учруулах зэрэг асуудлууд нэмэгдэж, хорлон сүйтгэх үйл ажиллагааны талаарх мэдээлэл солилцох, туслалцаа үзүүлэх, өргөтгөсөн хамтын ажиллагааны зохицуулалтууд нэмэгдсэн.

Конвенцын нэмэлт, өөрчлөлтөд орсон улс орон бүр цөмийн материалыг хулгайлах, хууль бусаар эзэмших, эдгээр учирч болох бодит аюул бий болсон тохиолдолд Олон улсын атомын энергийн агентлагт нэн даруй мэдэгдэх шаардлагатай. Энэхүү мэдээллийг үндэслэн тухайн улс өөрийн үндэсний аюулгүй байдлыг хангах, цөмийн террорист үйлдлээс урьдчилан сэргийлэх, бодит аюул тулгарсан тохиолдолд бусад орон холбогдох ОУБ-аас дэмжлэг авах боломжтой. Энэхүү нэмэлт, өөрчлөлтөд нэгдэн орсноор цөмийн материал болон цөмийн байгууламжийн биет хамгаалалтыг олон улсын түвшинд хүргэх, цөмийн терроризм, гэмт хэрэгтэй тэмцэх, олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх, эдгээр зорилтуудад нийцсэн үндэсний эрх зүйн орчныг бий болгоход дэмжлэг болно.

Конвенцын нэмэлт, өөрчлөлтөд нэгдэн орсноор Монгол Улс санхүүгийн ямар нэгэн үүрэг хүлээхгүй. Монгол Улсад мөрдөгдөж байгаа хууль тогтоомжтой зөрчилдсөн зүйл, заалт байхгүй болно.

Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 80 оны конвенцод 24 оны 11 сарын байдлаар 164 улс нэгдэн орж, 44 улс гарын үсэг зурсан байдаг. Тус конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлт нь 2016 оны 05 сарын 08-ны өдөр хүчин төгөлдөр болсон ба 24 оны 09 дүгээр сарын байдлаар 137 улс нэгдэн орсон байна.

Иймд Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 80 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэн дэмжиж өгөхийг хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Г.Тэмүүлэн:** Туваан сайдад баярлалаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Үг хэлэх гишүүд байна уу? Алга байна. Байна уу? Ганбат гишүүнээр тасалъя. Ганбат гишүүн үг хэлнэ.

**Д.Ганбат:** Уул нь асуулт байсан юм. Тэгээд асуугаад хариулчих ч хүн алга байх шиг байна. Тийм, тийм учраас би асуусан ч үгүй.

Гэхдээ нэг хэдэн үг хэлчихье гэж бодож байна. Олон улсын энэ конвенцод нэгдэнэ ээ гэдэг чинь маш их чухал ач холбогдолтой л доо. Ер нь байнга нэгдэж байх нь зөв юм байгаа юм. НҮБ-ын гишүүн орны хувьд, бага буурай орны хувьд, 2 том улс их гүрний орон дунд байдаг улсын хувьд, аль болохоор нэгдэж байх нь бид нарын энэ бүрэн эрхт улс, тусгаар улс гэдэг юманд бүрнээ нийцэж байгаа юм л даа. Гэхдээ энэ нэгэнт конвенцод нэгдсэн юм бол түүнийгээ бид нар биелүүлдэг байх ёстой. Ямар конвенцод нэгдсэн, нэгдээгүйгээ ч мэддэг ч үгүй, яагаад биелүүлээгүй вэ гээд тэрийгээ ч ярьж чаддаггүй. Ийм байж болохгүй ээ. Цааш цаашдаа энэ дээр бид нар бүр анхаармаар юм шиг байгаа юм. Энэ Аюулгүй

байдлын байнгын хороон дээр энийгээ л ярьж байх ёстой шүү дээ. Юу нь болоод, юу нь болохгүй байгаа юм. Хэрэв нэгдэж орчхоод, нэгдсэн хойноо тэр гэрээ конвенцын зүйл, заалтыг биелүүлэхгүй яваад байхаар чинь энэ Монгол Улсын нэр хүнд чинь тэр чигээрээ л уначхаж байгаа байхгүй юу. Нөгөө Монгол Улс өөрийнхөө хүлээсэн үүргээ биелүүлдэггүй, нөгөө НҮБ-ын 200 гишүүн орны яг нэгэн адил тэнд эрх үүргээ биелүүлэхэд, өө, та нар ингээд л байж л байдаг, тэгсэн мөртөө гэрээ конвенцоо биелүүлдэггүй ийм улс шүү дээ. Яг тэр байдлаараа одоо ингээд л дотооддоо хэрэгжиж байгаа хуулийг хуулийн дундаас нь болиулдаг болчихно шүү дээ. Үгүй ээ, энэ чинь хаанаас юу гарч ирж байгаа юм бэ? Иймэрхүү маягаар болохгүй ээ.

Бас аягүй бол энэ конвенцыг дундаас нь хэрэгжүүлж болохгүй байна энэ тэр гэж, хэрэгжүүлэхгүй болж болно энэ тэр гэж бодоод байгаа юм биш биз дээ. Ийм жишгийг бид нар байлгаж болохгүй. Энэ 126 гишүүнтэй парламент чинь илүү сайн ажиллаж, илүү энэ дээр ард түмэндээ, энэ улс орондоо энэ хэрэгтэй зүйлүүдийг сайн хэлж тайлбарлаж, энэ Засгийн газар нь ч гэсэн энийгээ хэлж тайлбарлаж байх ёстой шүү дээ. Энэ олон хүн ингээд эгнээд суучихсан байж байдаг. Тэрийгээ хэлж тайлбарлах нэг ч хүн байхгүй, зөв ойлголт хүн ч байхгүй. Яг доор нь юу боловсруулдаг, юм яадаг юм, тэр ажлаа хийдэг улсууд нь тухайн тэр дарга нартаа сайн тайлбарлаж өгөх ёстой шүү дээ. Тэд нар чинь бүгдээрээ яг мэргэжлийн хүмүүс байх албагүй. Энэ ийм ийм заалтыг чинь ингэж буруу хэрэгжүүлээд ингэвэл дараа нь ийм үр дагавар гардаг юм шүү гэдгийг хэлж байх ёстой шүү дээ.

Энэ Байнгын хорооны хурал дээр ч гэсэн та бүхэн үүнийг тайлбарлаад сууж байх ёстой шүү дээ. Энэ Аюулгүй байдлын байнгын хорооны гишүүд үүнийг ч гэсэн асууж, тодруулж, ярьж байх ёстой байхгүй юу. Нэгэнт тангараг өргөсөн Улсын Их Хурлын гишүүний хувьд. Үүнийг чинь л одоо парламент, үүнийг чинь одоо Монгол Улсын тусгаар тогтнолын баталгаа гэж яриад байгаа шүү дээ гэсэн ийм зүйлүүдийг товчхон та бүхэнд сануулчихъя. Цааш цаашдаа анхаарна биз.

**Г.Тэмүүлэн:** Ганбат гишүүнд баярлалаа.

Ганбат гишүүний хэлсэн саналыг анхаарч үзээрэй. Бид нар Гадаад яаман дээр ойрын хугацаанд ажиллахаар байгаад байгаа. Нийт Монгол Улсын нэгдэн орсон болон 305 орчим конвенц гэсэн тийм ээ. Энэ талаарх та бүхэн маань дэлгэрэнгүй судалгаа, танилцуулга, мэдээллүүдээ бид нарт бэлдэж өгөөрэй. Саяын тэр биелүүлсэн, биелүүлээгүй, хэрэгжилт нь хангалттай, хангалтгүй байгаад байгаа.

Мөн дээрээс нь цаашлаад юу гэдэг юм Монгол Улсын нэр хүнд сөргөөр нөлөөлөх ч гэдэг юм уу, үүрэг хариуцлагаа бид нар хангалттай хэмжээнд биелүүлээгүй байгаа ч гэдэг юм уу, энэ асуудлууд дээр тодорхой мэдээллүүд бэлдэж байгаарай гэдэг чиглэлийг өгч байна шүү.

Ингээд гишүүд үг хэлж дууслаа.

Санал хураалт явуулья.

Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн

томьёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд саналаа өгнө үү. Анхааралтай байгаарай. Санал хураалт.

Санал хураалтад 15 гишүүн оролцож, 11 гишүүн дэмжлээ. 73,3 хувиар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Байнгын хорооны санал, дүгнэлтийг танилцуулах байгаа. Танилцуулах гишүүн байна уу? Маргааш.

Жангабыл гишүүн танилцуулна.

Ингээд Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

15.58 цаг

3 дахь асуудалдаа оръё.

### **Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг явуулъя.**

Ажлын хэсэг мөн түрүүн танилцуулснаар хэвээрээ байна.

Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийн талаарх танилцуулгыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Цэвэгдоржийн Туваан сайд танилцуулна. Туваан сайдын микрофоныг өгье.

**Ц.Туваан:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын цөмийн энергийн салбарт 1972 оноос хойш Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх тухай гэрээ, Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх гэрээтэй холбогдсон баталгааг хэрэглэх тухай хэлэлцээр, Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай конвенц, Цөмийн ослын талаар шуурхай мэдээлэх тухай конвенц, Цөмийн террорист үйлдлийг хориглох тухай конвенц зэрэг 10 орчим олон улсын гэрээ конвенцод нэгдэн орсон бөгөөд эдгээр олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ амжилттай биелүүлсээр ирсэн.

Монгол Улсын Их Хурлын 2015 оны 06 сарын 19-ний өдрийн Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид байх статусыг шинэ түвшинд гаргах тухай 60 дугаар тогтоолоор Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколд нэгдэн орох арга хэмжээ авахыг Засгийн газарт даалгасан.

Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколд нэгдэн орсон улс, орнууд Олон улсын атомын энергийн агентлагаас томилсон хяналт шалгалтын байцаагч нарын томилгоог хүлээн авах, шаардлагатай тохиолдолд хил нэвтрэх эрх олгох, эрхийг шинэчлэх зэрэг үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, анхны тайланд тодорхойлсон байршил болон цөмийн материалын байршилд нэвтрэх эрхийг бүрэн олгох үүрэгтэй.

Мөн иж бүрэн баталгааны гэрээний дагуу тухайн улс орон Олон улсын атомын энергийн агентлаг болон түүний хяналт шалгалтын үүрэг гүйцэтгэж буй байцаагч нарт Олон улсын атомын энергийн агентлагийн халдашгүй дархан

эрхийн тухай гэрээний холбогдох заалтуудад тусгасан давуу эрх, халдашгүй байдлыг хангах үүрэгтэй.

Монгол Улс нь цөмийн байгууламжгүй бөгөөд бага хэмжээний цөмийн материалтай улсын хувьд Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколд нэгдэн орох нь өөрийн онцлог нөхцөл байдалд тохирсон цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх баталгааг хэрэгжүүлэх, улмаар цөмийн материалын ашиглалт хэрэглээнд үр дүнтэй хяналт тавих, цөмийн аюулгүй байдлын баталгааг гүйцэтгэхэд хянах техникийн чадавхыг бэхжүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах, цөмийн материалын хяналтын тооллогын улсын системийг бий болгох чиглэлээр Олон улсын атомын энергийн агентлагийн зөвлөх үйлчилгээ авах, дадлагажуулах хөтөлбөрт хамрагдах, цөмийн эрчим хүчний хөтөлбөр хэрэгжүүлэх баталгааг хангахад алхам ойртох зэрэг олон талын ач холбогдолтой юм.

Шинэчилсэн протоколд нэгдэн орсон оронд Монгол Улс санхүүгийн ямар нэгэн үүрэг хүлээхгүй. Монгол Улсад мөрдөгдөж байгаа хууль бусад хууль тогтоомжтой зөрчилдсөн зүйл, заалт байхгүй болно. Олон улсын атомын энергийн агентлагаас 2024 оны 10 сарын 01-ний өдөр Монгол Улсын Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Цөмийн энергийн комиссын даргад ирүүлсэн албан бичигт Олон улсын атомын энергийн агентлагийн захирлуудын зөвлөлийн шийдвэр 2005 онд гарснаас хойш багагүй хугацаа өнгөрсөн тул Монгол Улсын Засгийн газар зохих арга хэмжээ аваагүй тохиолдолд баталгааны дүгнэлтийг үргэлжлүүлэн гаргах боломжгүй болохыг мэдэгдсэн байна. Энэ нь Монгол Улсын нэр хүнд олон улсад буурах, Олон улсын атомын энергийн агентлагаас Монгол улсад хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр болон бусад дэмжлэг тусламжийг царцаах сөрөг үр дагавар үүсээд байгаа юм. 24 оны 11 сарын байдлаар Олон улсын атомын энергийн агентлагийн иж бүрэн цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх баталгааны гэрээнд 191 орон, Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколд 63 улс протоколын шинэчилсэн хувилбарыг даган мөрдөж байна.

Иймд Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэн дэмжиж өгөхийг хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Г.Тэмүүлэн:** Туваан сайдад баярлалаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? Батсүмбэрэл гишүүн, Эрдэнэболд гишүүн. Батсүмбэрэл гишүүнээр тасалъя. Эрдэнэболд гишүүн асуулт асууна.

**С.Эрдэнэболд:** Бид нар өнөөдөр ингээд 3 асуудал яг энэ шинэ тутам шинэ төрлийн эрчим хүчний эх сурвалжтай холбогдуулаад нийгэмд томоохон хэлэлцүүлэг болоод араас нь ингээд олон улсын гэрээ, конвенцод нэгдэн орох тухай явагдаж байгаа.

Тэгэхээр Туваан сайдаас асуухад энэ гарч байгаа 3 конвенцын яг ач холбогдол талаас нь та нэг энэ олон нийтэд яг ямар учраас энэ конвенцуудад нэгдэн орж байгаа бөгөөд энэ конвенцуудад нэгдэн орсноор Монгол Улсад яг ямар ач холбогдолтой. Нөгөө талаас хүмүүсийн нөгөө сэтгэл зовоод, санаа зовоод байгаа энэ байгаль, экологийн асуудал, хүний эрүүл мэндэд холбоотой асуудлууд, тийм ээ, энэ тээвэрлэх эд нар гээд нарийн деталь юмнууд явж байгаа учраас энэ

талаас нь яг энэ зайлшгүй нэгдэн орох ямар ач холбогдол байгаа талаас нь 1-д мэдээлэл өгөөч.

2-т нь болохоор, ер нь яг энэ төрлийн хэчнээн конвенц цаана нь манайх нэгдэн ороход дутуу тийм конвенцууд байна уу? Одоо ойрын хугацаанд, жишээлбэл, дахиад бид нарт зайлшгүй нэгдэн орох энэ чиглэлээр манай хууль нь хэрэгжээд, холбогдох төслүүд, хөрөнгө оруулалтууд яваад ирэхээр аюулгүй байдлын стандарт, хөдөлмөрийн аюулгүй байдал, экологийн асуудал гээд энэ чиглэлээр дахиад дутуу нэгдэн орох конвенц байгаа юу. Тэр өөрөөр хэлбэл Монгол Улс дахиад ойрын хугацаанд энэ чиглэлийн олон улсын конвенцуудад ямар, ямар конвенцуудад нэгдэн орох юм бэ гэж.

Тэгэхээр асуултаа дүгнээд хэлэхэд 1 дүгээрт, олон нийтэд энэ өнөөдрийн ярьж байгаа 3 конвенцын ач холбогдол, зайлшгүй шалтгаант шаардлага. Мөн ойрын хугацаанд нэгдэн орох ёстой, нэгдэн орох зохистой энэ конвенцуудын талаарх мэдээллүүдийг та нэгдсэн байдлаар хийгээч. Тэгэхгүй болохоор нөгөө хуулийн араас баахан конвенцууд ордог. Нөгөө гол нь энэ нөгөө жирийн нэгэн хууль биш энэ өөрөө нөгөө онцгой асуудал бид нар яригдаж байгаа учраас энэ чиглэл дээр энэ ажлын хэсгийнхэн ч гэсэн түрүүний хэлдэг олон нийтэд мэдээлэлжүүлэх, энэ хүрээндээ энэ конвенцуудын ач холбогдол, зайлшгүй шаардлагын талаар товч мэдээлэл хийх нь зөв байх гэж бодож байна. Үүнийг хариулж өгөхгүй юү?

**Г.Тэмүүлэн:** Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя. Туваан сайд.

**Ц.Туваан:** Өнөөдөр 3 конвенц орж ирж байгаа. Тэгээд энэ 3 конвенц маань мэдээж энэ Олон улсын атомын энергийн агентлаг гээд том агентлаг байгаа. Тэгээд Монгол Улс энэ Цөмийн энергийн комиссоороо дамжиж харьцдаг. Энэ цөмийн эх үүсвэр, цөмийн иж бүрдэл, технологи энэ хэрэглэж байгаа төхөөрөмжүүд гээд энэ олон зүйл бол олон улсад маш нарийн хэм хэмжээнүүдээр зохицуулагддаг, энэ зарим конвенц нь ийм бага хэмжээний жижигхэн зүйл зохицуулж байгаа юм шиг ийм харагдаж магадгүй. Тэгэхээр энэ нарийн зохицуулалтыг хийхэд бид бүхэн энэ Олон улсын цөмийн энергийн агентлагийн шаардлагын дагуу энэ конвенцуудад элсэж байгаа. Тухайлах юм бол бид нар тэр сая хамгийн сүүлд нь 3-д нь хэлсэн энэ Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг соёрхон батлах гээд энэ юун дээр конвенцод гэхэд л, бид нар аль 2005 онд энэ конвенц хэрэгжсэн. Бид нар 15 онд үүнийг орох нь зүйтэй гээд Засгийн газартаа даалгавар өгснөөс хойш 9 жил хэлэлцэж батлаагүй явахаар энэ дээр нэг үл ойлголцол ирж байдал ирж байгаа нь болохоор энэ нөгөө Олон улсын цөмийн атомын энергийн агентлагаас манайд ирсэн бичиг дээр энэ Монгол Улсын байр суурь их тодорхойгүй байна.

Дээрээс нь энэ конвенцод нэгдэн ороогүй тохиолдолд бусад төсөл, хөтөлбөрүүдэд оруулах дэмжлэг тусламжаа үзүүлэхгүй байх гэх мэт ийм сөрөг нөлөө гарахыг анхааруулсан байгаа.

Энэ конвенцод нэгдэн орсноор бид нар энэ цөмийн аюулгүй ажиллагаа, ялангуяа энэ ард иргэд рүүгээ чиглэсэн, байгаль орчин руу чиглэсэн, эрүүл мэнд рүү чиглэсэн, дээрээс нь энэ хөрш орнуудад энэ цөмийн бүтээгдэхүүнтэй холбоотой дайн байлдаан дэлхий даяар болж байна. Энэ дээр цөмийн зэвсгийн асуудал ч ярьж байна гээд иймэрхүү нөхцөл байдлуудад яаралтай мэдээлэх,

мэдэгдэх арга хэмжээ авхуулах энэ тэр гээд олон зүйлүүдийг зохицуулж, нарийвчилж зохицуулж өгсөн ийм конвенцууд байгаа гэдгийг хэлье.

Дээрээс нь одоо бид нар удахгүй бас 1 конвенц оруулж ирнэ. Манайх дээр бол тантай санал нэг байгаа зүйл нь бид нар үүнийг энэ Мон-Атомтой бусад юу, Бадрах Энержи энэ тэртэй нэлээн ярилцаж байгаа. Цөмийн энергийн комисс дээрээ ч гэсэн. Ард иргэдэд мэдээлэл өгөх асуудлыг сайн болгох, түүнд санхүү хөрөнгө зарцуулах, тэднийг багаас нь мэдлэгжүүлэх гэдэг энэ асуудлыг маш чухлаар авч үзэхгүй бол Монголчууд энэ атомын бөмбөг энэ тэр гэсэн тийм ээ, цөмийн энерги энэ тэр гэсэн энэ айхтар үг хэллэгүүдээс багагүй айж, ийм нэг ийм айлт, эмээх зүйл бий болсон байгаа учраас бид нар шинэ мэдээллүүдийг зайлшгүй өгч байх ийм шаардлага байгаа юм.

Таны асуусан энэ дутуу конвенц байгаа. Ашигласан түлшний болон цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагааны тухай 97 оны конвенцод нэгдэн орох гэдэг энэ асуудал байгаа. Бид нар үүнийг судлаад, энэ дээр яг цаг хугацааны юу хязгаар одоохондоо байхгүй. Бид бүхэн тодорхой зүйлүүдийг нэмж судалж байж, оруулж ирнэ гэсэн байдлаар түр хойшлуулаад байгаа гэдэг байдлаар хариулъя.

**Г.Тэмүүлэн:** Батсүмбэрэл гишүүн асуулт асууя.

**Н.Батсүмбэрэл:** Асуулт ер нь давхацчихлаа. Сая хариултыг нь ч сонсчихлоо. Тэгээд энэ гол юм бол нөгөө энэ нийтийн дунд байгаа төөрөгдөл, энэ үнэн зөв ойлголт. Одоо удахгүй энэ чинь та хэд чинь нөгөө ураныхаа хэлэлцээрийг хийж таарна. Гэрээ энэ тэр оруулж ирж таарна. Гэтэл нийтийн дунд арай өөр ойлголтууд яваад байдаг.

Тэгээд энэ дээрээ нэлээн өргөн хүрээтэй, цөмийн эрчим хүч, цөмийн энерги, уран, уран олборлолт, тээвэрлэлт, хадгалалт, хэрэглэхтэй холбоотой иргэдэд зориулсан нэг хэмжээнд. Иргэдээс гадна энэ шийдвэр гаргагч нэг бид чинь мэдэхгүй байна шүү дээ. Дээр тэр Байнгын хороон дээр ч билүү гишүүд чинь өөрсдөө ялгахгүй байна лээ шүү дээ. Энэ ураныхаа асуудлыг. Маргааш өглөө буу үйлдвэрлээд байлдах гэж байгаа юм шиг ойлгоод яваад байсан.

Тэгэхээр энэ түвшинд нь тааруулсан байдлаар мэдээллийг их шуурхай бэлдэж өгмөөр байна. Тэгэхгүй бол нийтийн дунд энэ маш их төөрөгдөл байгаад байдаг. Тэгэхээр энэ нэг мэдээллийнхээ түвшнийг жоохон ялгаад, энэ чинь нэлээн хэдэн эрдэмтэн, судлаач нар байлаа шүү дээ. Тэр нөгөө Тэгшбаяраас эхлээд. Тэгээд тэр та бүхэн юугаа гаргаад энэ нийт шийдвэр гаргаж байгаа түвшинд ямар хэрэгтэй вэ? Саяын Эрдэнэболд гишүүний асууж байгаа асуулт дотор миний явж байна, тэр хэдэн энэтэй холбоотой олон улсын гэрээ конвенц байдаг юм. Хэд нь манайх багтчихаад байгаа юм. Сая Туваан сайдын яриан дээр дутуу гарчихлаа. Хэд байдаг юм, дэлхийд. Хэдэд нь манайх нэгдчихсэн юм. Хэдэд нь нэгдэх юм, хэдэд нь нэгдэхэд ямар бэрхшээл байгаа юм, ямар үүрэг хүлээх юм. Манай Цөмийн энергийн үеийн тухай хууль өөрчлөгдөөд ямар давуу тал бий болж байгаа юм. Дагасан энэ компани, энэ тэр бусад нөгөө татвартай холбоотой асуудлууд нь яаж шийдэгдэж байгаа юм. Тэр Бадрах Энержи гэдэг чинь зөвхөн нэг компани нь. Монголд 10 гаруй орд байх шиг байгаа юм. Тэгээд эд нар цаашдаа ямар ямар байдалтай явах юм. Тэгээд дагалдаад яригдаад байдаг Мардай нь чухам ямар юм гээд энэ ойлголтуудыг олон түмэнд зориулж нэг, шийдвэр гаргаж байгаа хүмүүст

бас зориулж нэг өгөхгүй бол шийдвэр гаргаж байгаа микрофонд ярьж байгаа хүмүүс маань зурагт үзэж байгаа хүмүүстээ зориулж өөрсдөө яриад байна шүү дээ. Тэгээд үүнийг та бүхэн маань анхаарч ажиллаарай гэж хүсье.

**Г.Тэмүүлэн:** Туваан сайд.

**Ц.Туваан:** Батсүмбэрэл гишүүний асуултад тодруулж хариулъя. Монгол Улс яг өнөөдрийн байдлаар түрүүний миний уншсан 1972 оноос яг 10 олон улсын гэрээ конвенцод нэгдэн орсон байгаа. Тэгээд өнөөдрийн энэ 3, дутуу 1-тэйгээ нийлээд 14 конвенцод нэгдэн орох ийм төлөвтэй байна.

Мэдээллийг маш сайн өгнө өө. Тэгээд нийтдээ яг өнөөдрийн байдлаар гэхэд манайд нэг хайгуулын 3, ашиглалтын 7 лицензтэй компаниуд байгаа. Тэгээд нэлээн одоо компани тус бүрээр нь, лиценз тус бүрээр нь мэдээллийг өгье.

Дээрээс нь бид нар энэ Цөмийн энергийн комиссоос ийм хөөрхөн брошюруудыг хийгээд, энэ Ронагийн гэрээ хэлэлцэхээс өмнө гишүүддээ тарааж өгнө гэдгийг хэлье.

Дээрээс нь маргааш Пүрэвдорж гишүүнээр ахлуулсан парламентын гишүүд Казахстан улсад байгаа тэр Франц Казахын хамтарсан, байгуулсан тэр нөгөө яг манай энэ Ронагийн хөрөнгө оруулалтын гэрээ шиг энэ төсөлтэй танилцахаар ингээд явах гэж байгаа. Тэгээд жижигхэн зар хэлэхэд 1 хүн манай энэ Байнгын хорооноос ч юм уу ямар нэгэн виз байхгүй байгаа. Тэгээд 1 хүн нэмэгдэж явж болох боломж байгаа шүү гэдгийг та хэддээ хэлье.

Ганбат гишүүн санал тавьчихсан байгаа. Энхбаяр гишүүн явж болно. Билет бүх юм бэлэн байгаа. Виз байхгүй.

**Г.Тэмүүлэн:** Туваан сайд аа, Туваан сайд асуусан асуултад хариулаарай, Туваан сайд.

Батсүмбэрэл гишүүн болсон уу, тийм ээ.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Үг хэлэх гишүүд байна уу? Алга байна.

Ингээд санал хураалтыг явуулж эхэлье.

Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт.

Санал хураалтыг танилцуулъя. Санал хураалтад 15 гишүүн оролцсоноос 10 гишүүн дэмжиж, 66,7 хувиар дэмжигдсэн байна.

11 гишүүн, Сайнзориг гишүүн дэмжсэн юм байна.

Ингээд санал хураалтыг явуулж дууслаа. 11 гишүүн дэмжиж, саяын санал дэмжигдлээ.

Ингээд Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн чуулганд танилцуулах байгаа.

Батсүмбэрэл гишүүн яах уу. Тэгвэл Алтаншагай гишүүн яачих уу? Алтаншагай гишүүн тэгэх үү?

Алтаншагай гишүүн танилцуулъя.

Ингээд Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Ингээд өнөөдрийн хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ